

НОМ ЗҮЙН ШҮҮМЖ

ТӨВД ҮНДЭСТНИЙ ТОВЧ ТҮҮХ**(Чэнду, 1980) хэмээх номын тухай
(шүүмж)**

Хятадын орчин үеийн түүх бичлэгт төвдийн улс төрийн түүх, нэн ялангуяа төвд-хятадын харилцааны шинж байдлыг «төвд орон эрт дээр үеэс эхлэн ямагт Хятадын бүрэлдэхүүнд байсан» гэсэн хятад төвийн үзэлд захируулан тусгадаг билээ. Ингэхдээ орчин үеийн хятадын түүхчид, улс, нийгмийн байгууламжаа өөрсдөө цогцлон байгуулах төвдчүүдийн чадварыг бүрэн үгүйсгэж, харин хятадууд л тэдгээрийг бий болгож байгаа мэтээр дүрсэлдэг юм.

Дээрх зүйл нь Ван Фужэнь, Су Вэньцин нарын бичсэн «Төвд үндэстний түүх» хэмээх номын гол үндсэн санаа, агуулга нь болжээ. Уг номын зохиогчид БНХАУ-ын төвд муж бол эрт дээр үеэс хятадын салшгүй хэсэг бөгөөд төвдийн нийгэм улс төрийн байгууламж, соёл иргэншил нь хятадын нөлөөний дор бүрэлдэн тогтсон хэмээн батлах гэсэн тодорхой зорилго тавьсан нь илт байна.

Зохиогчид VII—IX зууны төвд-хятадын харилцаанд онцгой ач холбогдол өгч, чухамхүү энэ үеэс эхлэн төвд улс хятадын салшгүй хэсэг болох үндэс тавигдсан мэт бичжээ. Гэтэл төвдийн эрт дээр үеийн болон дунд зууны үеийн түүхэн сурвалж бичгүүдэд дээрх зүйлийг нотлох баримт үгүйгээр үл барам тэр үеийн төвд-хятадын харилцаа их ээдрээтэй байсан ба хоорондоо байлдаж байсан тухай олон мэдээ сэлт байдаг байна.¹

VII—IX зууны үеийн төвд-хятадын харилцааны шинж байдал нь Тан улс ба төвдийн хаант улс хоёр адил тэгш эрхтэй хөрш орнуудын байдалтай байсан бөгөөд төвд улс Хятадын хараат гэх ямар ч үндэс байсангүй. Төвд-хятадын хэлхээ холбоо VII—IX зуун хүртэл үргэлжилж байгаад Тан улс мөхөж, Төвдийн хаант улс задарч хэд хэдэн жижиг вант улс болсон нь төвд-хятадын хэлхээ холбоо тасарч зөвхөн XIII зуунд Монголын байлдан дагуулагчид Хятадыг эзэлж, Төвдийг монголын харьяат болгосон тэр үеэс дээрхи холбоо дахин сэргэжээ. Өгүүлж буй номонд ч IX—XIII зууныг хүртэлх төвд-хятадын харилцааны талаар нэг ч зүйл дурдаагүй нь мөн үүгээр тайлбарлагдах бизээ.

Монголчуудын байлдан дагууллын үр дүнд бий болсон Юан гүрний үеийг уг номонд «Хятад улсын их нэгдлийн үе» гээд тэр үед Төвд орон хятадын бүрэлдэхүүнд бүрмөсөн орсон юм гэх мэтээр түүхийн үнэнийг завхруулан бичжээ. Юан гүрний үед Төвд, Хятад

¹ Р. Е. Пубаев. «Пагсам Чжонсан» --памятник тибетской историографии XVIII века. Новосибирск. 1981.

орон монголын байлдан дагуулагчдын ноёрхолд байсныг үгүйсгэн «хятад улсын их нэгдлийн үе» гэж бичиж байгаа нь хятад төвийн үзлийн «хятад эрт дээр үеэс олон үндэстээ ястнаар бүрэлдсэн нэгдмэл гүрэн» байсан гэсэн санааг нотлох гэсэн оролдлого юм.

1368 онд Юан гүрэн мөхснөөр Төвд орон Хятад улсын нэгэн адил өөрийн тусгаар тогтнолоо сэргээсэн билээ. Гэтэл уг номын зохиогчид Төвд нь Мин улсын үед хятадын хэсэг байсан гэж завхруулан бичжээ. Тухайлбал «Мин улс Төвдөд энх тунх тогтвортой байдлыг бий болгосноор эдийн засаг, соёл их хэмжээгээр хөгжиж төвд-хятад үндэстний харилцаа нэгэн гэр бүлд дэлгэрэн хөгжиж байсан» мэт бичсэн байна. (81-р тал) Үнэн хэрэг дээрээ Мин улс Төвдөд ямарваа нэгэн нөлөө үзүүлж чадаагүй бөгөөд зөвхөн улс төрөөс худалдаа арилжааг илүү сонирхдог байсан Дорнод Төвдийн сүм хийд, хошуудтай элчин яамны хэмжээнд хэлхээ холбоо тогтоосон байжээ.²

XVI--XVII зууны төвд-монголын харилцааны талаар өгүүлсэн хэсэгт Монгол улсыг хятадын түшмэг байсан гэж түүхийг мөн л завхруулан бичжээ. Зохиогчид Зүүнгарын хаант улсыг мөн л хятадын нэг хэсэг байсан гэж гуйвуулан бичиж, XVII зууны үед Зүүнгар нь манжийн түрэмгийллийн эсрэг нөлөө бүхий хүч байсныг үгүйсгэсэн байна. Мөн манжийн дарлалын эсрэг төвдийн ард түмний эрх чөлөөний тэмцлийн мөн чанарыг гуйвуулан «төвдийн эрх баригчид, төвдийн ард түмэн хятадын бүрэлдэхүүнд байх чин үнэн хүсэл эрмэлзлэлтэй байсан» гэж бичжээ. Чингэхдээ зохиогчид хятад ч гэсэн манжийн дарлалд байсан, буюу манж нар төвдийн ч хувьд, хятадын ч хувьд харийн булаан эзлэгчид байсныг огт мартсан бололтой.

Төвдийн соёл өвөрмөц бөгөөд хөрш зэргэлдээ ард түмнүүдийн, ялангуяа энэтхэгийн соёл, буддын шашин, түүнчлэн Төв Азийн ард түмний соёл харилцан ихээхэн нөлөөлж байсан байна. Харин хятадын соёл иргэншил төвдийн соёлд мэдэгдэхүйц нөлөөлж чадаагүй билээ. Гэтэл уг номонд Төвд дахь хятадын соёлын нөлөөг дэвэргэн бичсэн нь дээрх хүчин зүйлийг үгүйсгэхэд хүргэжээ.

Зохиогчид эртний төвдийн нийгэм эдийн засгийн байгууллыг боол эзэмшилт байгуулал гэж тодорхойлохдоо төвдийн тухайн үеийн нийгмийн үйлдвэрлэлийн харилцааны шинж чанарыг үндэслэл болгожгүй, харин эртний судар бичигт төвдөд боолчууд байсан гэсэн мэдээг иш үндэс болгосон нь шинжилгээний хувьд туйлын хангалтгүй байна.

Уг номыг зохиоход хэрэглэсэн сурвалж бичиг ба судалгааны зохиолын хувьд яривал зохиогчид төвдийн эрт, дунд зууны үеийн түүхээр бичигдсэн Гунгаажалцангийн «Гаадан багшийн сургаалын түүх», «Мялын шастир» зэргийг ашигласан боловч ихэнхдээ хятадын эртний сурвалж бичигт тулгуурлажээ. Мөн бусад хэл дээрх төвдийн түүхийн холбогдолтой түүхийн сурвалж, тухайлбал «XVIII зууны төвдийн түүх бичлэгийн эх сурвалж болох Сүмбэ Хамба Ишбалжирын «Пагсам Чжонсан» шастирыг огт ашиглаагүй нь харамсалтай. Нөгөө талаар орчин үеийн төвдийн судлалаархи бүтээлүүдийг зохиогч ер ашигласангүй.

Н. Ариунгуа

² В. А. Богословский. БНХАУ-ын төвд муж. УБ., 1982. 17-р тал: